

ХҮНИЙ ЭРХ-БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХ-ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ



ЭРХЭЭ ХАМГААЛАХ ГАРЫН АВЛАГА



GAGGA GLOBAL ALLIANCE
FOR GREEN AND
GENDER ACTION

**ma
cash**
(one changes the world)

fcam
FOR CHANGE AND ACTION

Both ENDS
Connecting people for change

ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

Энэхүү гарын авлага нь олон улсын хэмжээнд бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, байгаль орчны эрх болон байгалийн баялгийг ашигласны өгөөжийг эмэгтэйчүүд тэгш хүртэх эрх, сөрөг нөлөөнд бусдаас илүү өртөхгүй байх эрх, хүний эрхийг хамгаалах эрх зүйн заалт, зарчмуудыг товч танилцуулж Таны хүний эрх зөрчигдсөн тохиолдолд гомдол хэрхэн, хаана гаргах заавар түгээх зорилготой.

НОГООН БА ЖЕНДЕРИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТӨЛӨӨХ ГЛОБАЛ АЛЪЯНС (Global Alliance for Green and Gender Action) төсөл нь байгалийн баялгийг ашиглах явцад хүний байгаль орчны эрхүүд: газар ус, бэлчээр ашиглах, эрүүл аюулгүй орчинд амьдрах үндсэн болон эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхүүд зөрчигдөх бөгөөд энэ явцад эмэгтэйчүүд илүү их хохирох эсвэл илүү ачаа үүрэх нь нийтлэг болсныг олон улсын хүний эрхийн байгууллагууд тогтоож, сөрөг нөлөөг арилгуулахад нөлөөлөх зорилготой болно. Хүний эрх, байгаль орчны эрхүүдийг хамгаалах зарчим, стандарт, жендерийн бодлого зэргийг хэрэгжүүлэх удирдамжуудын талаарх мэдээлэл түгээж, зөрчлийг орон нутагт иргэд хэрхэн хянах, зөрчилтэй хэрхэн арилгуулах тухай сургалт зохион байгуулах, шүүхийн болон шүүхийн бус гомдол барагдуулах хэрэгслүүдийг ашиглахад нь хохирсон иргэдэд техникийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлдэг болно.

МУ-д уул уурхай, эрчим хүч ба дэд бүтцийн төслүүдэд Дэлхийн Банкны Групп (ДБГ), түүний компанид зээл олгогч Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Европын Сэргээн Босголтын Банк (ЕСББ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ), Азийн Хөгжлийн Банк (АХБ) зэрэг олон улсын банкууд санхүүжүүлж байгаа бөгөөд банкуудын байгаль орчин ба нийгмийн хамгааллын бодлогыг зөрчсөн тухай гомдол хүлээн авах механизмуудаас сонгон танилцуулж байгаа болно.

ОУСК-ийн байгаль орчин ба нийгмийн хамгааллын бодлого нь олон улсын санхүүгийн салбарт мөрдөгддөг стандарт хэмээн хүлээн зөвшөөрөгдсөний хувьд ОУСК-ийн Нийцэл, Зөвлөлгөө ба Эрхийн хамгаалагч (омбудсманы) газрын гомдлын зааварчилгааг энд танилцуулж байна. ДБГ, АХБ ба бусад банкуудын нийцлийн хяналтын, маргаан шийдвэрлэх зэрэг шүүхийн бус хэрэгслүүд нь бага зэргийн ялгаатай ч зарчмын хувьд ойролцоо журмуудтай бөгөөд тэдгээрт гомдол гаргахад тус тусын журам ба маягтыг ашиглан гомдол гаргана (гомдлын сайтуудын хаягийг арын хуудаснаас үзнэ үү)

Гарын авлагыг олон улсын банкны санхүүжилттэй төслийн сөрөг нөлөөнд өртөж эрх нь зөрчигдсөн гомдолтой нутгийн хүн ам зөрчигдсөн эрхээ сэргээн эдлэх, хохирлыг барагдуулах гомдол гаргахад дэмжлэг болгох зорилготой боловруулсан болно.

Гарын авлагад мөн МУ-ын Үндсэн хууль, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, эмэгтэйчүүдийн эрхийн заалтууд, бизнес хүний эрхийг хүндэтгэн ажиллах зарчмууд, зөрчсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн болон бизнесийн үүргийн тухай заалтуудыг багтаасан болно.

Энэхүү хүний байгаль орчны эрх эмэгтэйчүүдийн эрхийг тэгш хамгаалах олон улсын хэм хэмжээг ашиглах тухай гарын авлагыг Global Alliance for Green and Gender Action (GAGGA) төслөөс санхүүжүүлж байгаад талархал илэрхийлж байна.

АГУУЛГА

Монгол улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйл.....	2
Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас.....	4
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эрхийн талаарх баримт бичгүүдээс.....	7
ОУСК-ийн Гомдлын механизмын танилцуулга, заавар	10
НЗЭХ-д гаргах гомдлын загвар захидал	12
АХБ-ны Хариуцлагын механизмын танилцуулга	14
АХБ-ны Гомдлын маягт	16
НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн зарчмуудаас	18
Мэдээлэл авах веб хаягууд.....	арын хавтас

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС

Арван зургаадугаар зүйл.

Монгол улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

- 1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;
- 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
- 3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;
- 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;
- 5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;
- 6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;
- 7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;
- 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;
- 9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;
- 10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;
- 12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;
- 13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны

нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

- 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;
- 15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;
- 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;



Зураг дээр: Гэр хорооллын нүүлгэлтэд өртсөн 60 өрхийг түр байраар хангах болов <http://ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=23079>

Газрыг уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, хот байгуулалтын зорилгоор ашиглах явцад нүүлгэлтэд хамгийн их өртөж газар эзэмших, орон гэртэй байх улмаар ажилтай, амьжиргаатай байх эрхээ алдаж хохирдог нь эмэгтэйчүүд гэдгийг олон улсад судалгаагаар тогтоогоод байгаа нь МУ-д ч илэрч байна. Улаанбаатар хотын гэр хорооллын хөгжил, хөрөнгө оруулалтыг дэмжих АХБ-ны төслүүдийн нүүлгэлтэд өртөн гомдол гаргагчдын 80 гаруй хувь нь эмэгтэй, 36 хувь нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.

- 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;
- 18/ улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛААС

1 дүгээр зүйл: Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой.

2 дугаар зүйл: Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй ба олон улсын статусаар ялгаварлах, тухайлбал, бусад улсын эзэмшилд эсвэл өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь хязгаарлагдмал байгаа нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

3 дугаар зүйл: Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

4 дүгээр зүйл: Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.

5 дугаар зүйл: Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.

6 дугаар зүйл: Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

7 дугаар зүйл: Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа ялгаварлан гадуурхалтаас болон тийнхүү гадуурхалтаас өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

8 дугаар зүйл: Үндсэн хууль ба бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.

9 дүгээр зүйл: Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

10 дугаар зүйл: Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

11 дүгээр зүйл:

1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.

2. Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тэр үед ноогдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй.

12 дугаар зүйл: Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

13 дугаар зүйл:

1. Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.

2. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.

14 дүгээр зүйл:

1. Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй.
2. Улс төрийн бус гэмт хэргийн улмаас буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсэний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдлэж үл болно.

15 дугаар зүйл:

1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй.
2. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй.

16 дугаар зүйл:

1. Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ.
2. Нөхөр, эхнэр болох хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно.
3. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

17 дугаар зүйл:

1. Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй.
2. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй.

18 дугаар зүйл: Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.

19 дүгээр зүйл: Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

20 дугаар зүйл:

1. Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.
2. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй.

21 дүгээр зүйл:

1. Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.
2. Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.
3. Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.

22 дугаар зүйл: Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.

23 дугаар зүйл:

1. Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй.
2. Хүн бүр ямар ч алагчилалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй.
3. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.
4. Хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй.

24 дүгээр зүйл: Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.

25 дугаар зүйл:

1. Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй.
2. Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой.

26 дугаар зүйл:

1. Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой. Техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой. Авьяас чадвартай нь уялдан хүн бүрт дээд боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох ёстой.
2. Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.
3. Хүүхэддээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдлэнэ.

27 дугаар зүйл:

1. Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.
2. Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

28 дугаар зүйл: Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдлэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй.

29 дүгээр зүйл:

1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана.
2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.
3. Эдгээр эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй.

30 дугаар зүйл: Энэхүү Тунхаглалын ямар ч зүйлийг аль нэг улс, бүлэг буюу бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах буюу тийм үйлдэл хийх эрх олгож байгаа мэтээр мушгин тайлбарлаж болохгүй.

Охид, эмэгтэйчүүд нь хүний бүх эрхийг бүрэн болон тэгш эдлэх эрхтэй бөгөөд яливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцлийг хангах нь төрөөс хүний эрхийг хамгаалах, энх тайван аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл болно.

Охид, эмэгтэйчүүдийн эрхэд хүний бүх эрх орох бөгөөд амьдралын бүх талбар – эрүүл мэнд, боловсрол, улс төр ба эдийн засгийн харилцаанд оролцох, эрүүл аюулгүй орчинд орон гэртэй, зохистой амьжиргаатай амьдрах болон ямар ч нөхцөлд хүчирхийллээс ангид байх зэрэг бүх эрхүүд орно.

НҮБ-ЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗОХИСТОЙ АМЬЖИРГААНЫ СТАНДАРТААР ХАНГАГДАХ ЭРХ:

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)-ын Бүлэг 11-т “зохистой хүнс, хувцас ба орон байраар хангагдах болон амьжиргааныхаа нөхцлийг байнга сайжруулах боломжоор хангагдах эрхүүдийг” амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрхийн хүрээнд жагсаасан байдаг. Эмэгтэйчүүдийн газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрх, ус ба хүнс, ариун цэврийн нөхцөл болон ажлын байраар хангагдах, нийгмийн халамж авах эрхүүд нь бүгд зохистой амьжиргааны стандартаар хангагдах эрхийн салшгүй хэсгүүд юм. Дээрх эрхүүд нь олон улсын хүний эрхийн эрх зүйгээр баталгаажсан бөгөөд эрэгтэй хүнтэй тэгш эрх эдлэхээр заасан байдаг. Эмэгтэйчүүдийн нийгмийн үйлчилгээ авах, боловсрох, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд чухал үүрэгтэй. Газар, үл хөдлөх хөрөнгө, орон сууц өмчлөх, захиран зарцуулах эрхүүд нь эмэгтэйчүүд болон үр хүүхдүүдийн зохистой амьжиргаатай, эдийн засгийн болон биеийн аюулгүй байдлыг хангахад чухал хүчин зүйлсүүд юм.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХ:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Бүлэг 17.1 ба 2-т “хүн бүр хүйсээс үл шалтгаалан өмч хөрөнгө өмчлөх эрхтэй”, Бүлэг 25-д “зохистой амьжиргаатай,

орон гэртэй болон амьжиргаа алдагдсан тохиолдолд аюулгүй байдал хангагдсан байх эрхтэй”; мөн Бүлэг 16-д “хүн бүр гэрлэх эрхтэй, гэрлэлтийн хүрээнд болон гэрлэлт цуцлахад эрх тэгш байна” гэж заасан байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОУП)-ын Бүлэг 26-д үл ялгаварлах заалтын хүрээнд хуулийн өмнө эрх тэгш байхыг зааж хүйсээр ялгаварлахыг хориглосон болно. Энэ нь үл хөдлөх хөрөнгө, орон байр болон газар өмчлөх тухай хууль ба бодлогод хамаарна.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (СЕ-DAW)-ийн Бүлэг 14.2-г хөдөөгийн эмэгтэйчүүдийг ялгаварлалтаас хамгаалах, зохистой амьжиргаа, орон байраар хангагдах эрхийг онцлон хамгаалахыг зөвлөсөн байдаг.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ:

1996 оны НҮБ-ын Хүний хабитатын тухай (Habitat II) Истамбулын хурлаас хүн амын суурингийн хөгжил дэх эмэгтэйчүүдийн эрхийг тодорхойлохдоо албадан нүүлгэлтэд эмэгтэйчүүд бусдаас илүү өртөж байгааг онцлон эмэгтэйчүүд газар, орон байр өмчлөх эрхийг хуулиар баталгаажуулан хамгаалах, зөвхөн зайлшгүй тохиолдолд олон улсын стандартыг ханган газар чөлөөлөлтөд хамруулж байхыг заасан байдаг. Эмэгтэйчүүдийн орон гэртэй байх эрх баталгаажсан тохиолдолд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нөхцөл бүрдэнэ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд ба тэдний хүүхэд орон гэргүй болдог бөгөөд орон гэрийн эзэн эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх нь бага байдаг нь хүчирхийллээс зугтахын тулд хүчирхийлэгч эрэгтэйг гэрээс зайлуулах биш эмэгтэй хүн гэрээсээ дайжина гэдэг нийтлэг хандлагаас хамгаалах зорилготой.

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ЗЭЭЛ АВАХ ЭРХ: CEDAW-ийн Хорооны зөвлөмжид эмэгтэйчүүд гэрээ хэлцэлд оролцох, гэрээ байгуулах, нөхөр эсвэл эрэгтэй гэр бүлийн гишүүний зөвшөөрөл авах нөхцөлгүйгээр санхүүгийн зээл авах эрхүүдийг хуульчлан хангахыг заасан. Эмэгтэйчүүд нүүлгэлтийн нөхвөр, бусад аливаа нөхөн олговрын хамтран эзэмшигч байх, өрх тэргүүлсэн эсвэл бэлбэсэн эмэгтэйчүүдэд өөрийн нөхөн олговор олгогдоно.

ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ БАРИМТ БИЧГҮҮД:

- 1980: Эмэгтэйчүүдийн төлөө Дэлхийн 2-р бага хурал (Копенгаген)-ны Эмэгтэйчүүд, хүүхдийг бие мах бодь ба сэтгэл санааны хүчирхийллээс хамгаалах хөтөлбөрүүд боловсруулж хэрэгжүүлэх тухай Тогтоол.
- 1985: Дэлхийн 3-р бага хурал (Найроби)-йн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хохирогчийг дэмжих ба олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэргийг үндэсний хууль эрх зүй ба бодлогод суулгаж хэрэгжүүлэх тухай Тогтоол.
- 1979: Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW) ба Нэмэлт Протокол (2000). Конвенцийн Ерөнхий зөвлөмж 12 ба 19-д гишүүн орнуудад хандсан тодорхой зөвлөмжүүд тусгагдсан.
- 1985: Гэр бүлийн хүчирхийллийн тухай Ерөнхий Ассамблейн Тогтоол (А/

RES/40/36).

- 1989: Хүүхдийн эрхийн тухай конвенц. Хүүхдийн жам ёсны эрх, хамгаалал болон эцэг эхийн хүчирхийлэл (Бүлэг 19), бэлгийн мөлжлөгө (Бүлэг 34) болон хүний наймаанаас хамгаалагдах (Бүлэг 35) эрхийг тодорхойлсон байна.
- 1993: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал ба НҮБ-ын тусгай илтгэгчийн мандат байгуулагдсан.
- 1994: Олон улсын Хүн амын ба Хөгжил бага хурлаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийг хооронд нь холбож үр дагаварыг арилгах, урьдчилсан сэргийлэх тухай заалтууд бүхий баримт бичиг.
- 1995: Бээжингийн Үйл ажиллагааны платформ—хүчирхийллийг нарийн тодорхойлж урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээг тогтоосон.
- 2004: Хүний наймаа, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор наймаалах асуудал эрхэлсэн Тусгай илтгэгч томилогдсон.
- 2006: Ерөнхий ассамблейн Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг судалсан анхны тайлан гарсан.
- 2008: НҮБ-ын UNiTE эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахын төлөө нэгдэх хөдөлгөөн: 1) охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хуулиар зохицуулж, шийтгэлийн тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх; 2) Олон сектор хамруулсан үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж хэхэгжүүлэх; 3) Охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээллийг цуглуулах; 4) Олон нийтийн мэдээлэл, нийгмийн хүчийг дайчлах; болон 5) 2015 он гэхэд дайн, мөргөлдөөний орчинд бэлгийн хүчирхийллийг шийдэх.
- 2010: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтыг эрчимжүүлэх тухай Хүний эрхийн Зөвлөлийн 14/12 тоот Тогтоол

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙ ХООЛ ХҮНС, УС ба АРИУН ЦЭВРИЙН НӨХЦЛӨӨР

ХАНГАГДАХ ЭРХ: Хоол хүнс, ус ба ариун цэврийн нөхцөлөөр хангагдах нь эмэгтэйчүүдийн бусад эрхүүдээ бүрэн гүйцэд эдлэхэд нөлөө бүхий хүчин зүйлс юм. ЭЗНСЭОУП –ын 11-р Бүлэгт хүн бүрийн хоол хүнсний эрх, өлсгөлөнгөөс ангид байх эрхийг заасан байдаг. ЭЗНСЭОУП –ын Хорооны Ерөнхий тэмдэглэл №.12 (1999) зохистой хүнс болон хоол хүнс нь хүртээмжтэй (биет ба эдийн засгийн хувьд) байх тухай заалт байдаг.

2010 онд Ерөнхий Ассамблей 64/292 тоот Тогтоолоороо цэвэр ус ба ариун цэврийн нөхцлийг хүний эрх хэмээн хүлээн зөвшөөрсөн.

ЭЗНСЭОУП-ын Бүлэг 11-т.1) биеийн болон сэтгэцийн хамгийн өндөр стандартын эрүүл мэндтэй байх эрхийг ус ба ариун цэврийн нөхцөлөөр хангагдах эрхтэй хамааруулж тодорхойлсон баримт бичгүүд дагалдан гарсан. ЭЗНСЭОУП-ын Хорооны Ерөнхий тэмдэглэл № 15 (2002)-д хөдөөгийн хүн ам, түүний дотор эмэгтэйчүүдийн усны эрхийг онцгойлон зохистой чанар ба хэмжээний усыг тэгш, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтгүй хүртэх нөхцөл бүрдүүлэхийг заасан байна.

Нийцэл, Зөвлөлгөө, Эрхийн хамгаалагч (НЗЭХ) гэж юу вэ?

НЗЭХ нь Дэлхийн Банкны Группийн хувийн хэвшилд зээл олгох – Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг (ОТХОБА - MIGA)–ийн хараат бус гомдол барагдуулах шүүхийн бус хэрэгсэл юм. Энэ хоёр байгууллага нь дэлхийн улс орнуудад хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар ядуурлыг бууруулах үүрэгтэй. ОУСК-ийн санхүүжилттэй төслийн сөрөг нөлөөлөлд өртсөн, өртөж болзошгүй хүмүүс НЗЭХ-д хандаж гомдлоо гаргаж болно. НЗЭХ нь холбогдох бүх талуудыг оролцуулан төсөл хэрэгжих газар хүний эрх ба байгаль орчны байдлыг сайжруулах бодит шийдлийг олох үүрэгтэй.

Хэн гомдол гаргаж болох вэ?

ОУСК-ийн төслөөс гарах сөрөг нөлөөлөлд өртөж буй эсвэл өртөж болзошгүй гэж үзсэн хувь хүн, бүлэг, нутгийнхан эсвэл өөр талууд НЗЭХ-д гомдол гаргаж болно. Гомдлыг мөн сөрөг нөлөөлөлд өртөж буй талуудыг төлөөлөн гаргаж болно.

Гомдолд ямар шаардлага тавигдах вэ?

НЗЭХ хүлээн авч шалгахын тулд гомдол дараах 3 шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Гомдол нь ОУСК эсвэл MIGA төсөлд хамаарах (түүний дотор бэлтгэгдэж буй дэд төслүүд)
2. Тухайн төслийн нийгэм ба байгаль орчны асуудлуудад хамаарах гомдол
3. Гомдол гаргагчид нь гомдлын шалтгаан болох байгаль орчин ба нийгмийн нөлөөлөлд өртөж буй, өртөж болзошгүй гэж үзэж байгаа хүмүүс байх.

Ямар гомдлыг хүлээж авахгүй вэ?

- Дээрх гурван шалгуурыг хангаагүй гомдлыг НЗЭХ хүлээж авах боломжгүй. Хэрэв гомдол нь ОУСК эсвэл MIGA-аас бусад байгууллагад хамаарах бол холбогдох байгууллагад нь уламжилж болдог.
- Авилга ба хууран мэхлэх ажиллагаанд холбогдох гомдлыг Дэлхийн Банкны Группийн Шудрага байдлын газар хүлээн авна. НЗЭХ нь ОУСК ба MIGA-ийн тендерийн ажиллагаанд холбогдох гомдлыг авдаггүй.
- НЗЭХ нь муу санаа бүхий, жижиг эсвэл давуу тал олох зорилго бүхий гомдол хүлээж авахгүй.

Гомдол гаргахад нотлох баримт гаргах хэрэгтэй юу?

Гомдол гаргахын тулд нотлох баримт гаргах шаардлагагүй. Гэхдээ өөрийн гаргаж буй гомдолд холбогдох мэдээлэл гаргаж өгөхийг хүсч байгаа бол хүлээж авна.

Нууцлал хадгалах хүсэлт гаргаж болох уу?

Болно. НЗЭХ нууцлалд чухал ач холбогдол өгдөг бөгөөд хүсэлт гаргасан тохиолдолд гомдол гаргагчдын мэдээллийг задруулахгүй. Нууцлах хүсэлт гаргасан тохиолдолд гомдлыг шийдвэрлэх үйл явцыг гомдол гаргагчтай зөвлөлдөж тохирно. Үүний зэрэгцээ, гомдолд холбогдох мэдээллийг гомдол гаргагчийн зөвшөөрөлгүй задруулахгүй.

НЗЭХ таны гаргасан гомдлыг гаргасан хэл дээр нь хүлээн авна. Ажлын 15 хоногийн дотор (орчуулга хийх хугацаа үүнд орохгүй) НЗЭХ нь гомдол хүлээж авч судлах эсэхээ мэдээнэ. Хэрэв дээрх шалгуурыг хангасан бол НЗЭХ гомдлыг судлан үзэж маргааныг шийдвэрлэхээр гомдол гаргагчтай хамтран ажиллана. НЗЭХ мэргэжилтэн тантай биечлэн холбоо тогтооно.

Гомдлыг шийдвэрлэх үйл явц ямар журамтай вэ?

Хүлээн авсан гомдол тухай бүрт НЗЭХ тодорхой журмыг мөрдлөгө болгон ажиллаж маргааныг хугацаанд нь шийдвэрлэх зорилго тавьж ажилладаг. Хэрэв гомдол нь НЗЭХ-ийн 3 шалгуурыг давсан бол:

- НЗЭХ-ийн Эрхийг хамгаалагч (Ombudsman) эхлээд гомдол гаргагч, төсөл хэрэгжүүлэгч, бусад талуудтай хамтран гомдлыг шийдвэрлэх бүх талууд хүлээж авах боломжтой шийдэл хайна. Гомдлыг судлах, шийдэл хайх зэрэг ажиллагааг 120 хоногт багтана.
- Маргааныг шийдвэрлэхэд талууд санал нийлэхгүй, зөвшилцсөн шийдэл олохгүй бол НЗЭХ-ийн Нийцлийн хэсэг ОУСК-ийн төслийн үйл ажиллагаа нь нийгэм ба байгаль орчинд холбогдох бодлогуудыг хэрэгжүүлж байгаа байдалд нь нийцлийн үнэлгээ хийж аудит оруулах эсэхийг тогтоодог.

НЗЭХ-ийн Омбудсман хэрхэн ажилладаг вэ?

НЗЭХ-ийн Омбудсман гомдлыг судалж үзээд талуудад хамгийн боломжийн байдлаар маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. Омбудсман нь гомдлын талаар дүгнэлт гаргахгүй, шийдвэрийг тулгахгүй мөн гэм бурууг тогтоохгүй. НЗЭХ-ийн мэргэжилтнүүд талуудтай хамтран маргааныг шийдвэрлэх арга замуудыг хайдаг. Үүнд хамтарсан мэдээлэл цуглуулах, талуудын хооронд хэлэлцүүлэг хийлгэх, талуудын маргаанд зуучлах, хэлэлцээрийн талбар нээж өгөх эсвэл хамтарсан хяналтын хөтөлбөр тохирох зэрэг орно. НЗЭХ-ийн мэргэжилтнүүд шүүхийн бус маргаан шийдвэрлэх аргуудад сургагдсан бөгөөд маргааныг үнэлэх, зуучлах болон олон талт хэлэлцээг хэрэгжүүлэх чадавхтай. Тэрээр хөгжлийн төслүүдийн зөвшилцөл, зөвлөлдөх явцыг тухайн орны нөхцөл байдлыг мэддэг хараат бус мэргэжлийн зуучлагч нартай ажилладаг. НЗЭХ-ийн ажлын тухай мэдээллийг цахим хуудаст байршуулсан мэдээллээс үзээрэй.

НЗЭХ-ийн Нийцлийн үүрэг юунд оршдог вэ?

Омбудсманы аргаар маргааныг шийдвэрлэх боломжгүй бол гомдлыг Нийцэлд шилжүүлдэг. Нийцлийн байдлыг шалгахын үндэслэл нь гомдлын шалтгаан болсон асуудлууд нь ОУСК эсвэл MIGA-ийн тухайн төслийн нийгэм ба байгаль орчны үнэлгээтэй холбоотой зөрчил байж болзошгүйд оршино. НЗЭХ үнэлгээ хийгээд аудит оруулах шаардлагатай бол хэргийг шалгах хараат бус баг бүрдүүлэн ажилладаг. Цуглуулсан мэдээллийг нийтэд танилцуулах бөгөөд НЗЭХ-аас зөвлөмжийн биелэлтийг төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаагаа бодлого ба журамд нийцүүлэх хүртэл нь хянадаг. Нийцлийн аудит нь ОУСК ба MIGA-д чиглэсэн байх бөгөөд төсөл хэрэгжүүлэгчид (зээл авсан хувийн хэвшлийн үйлчлүүлэгч) хамаардаггүй.

Гомдлоо хэрхэн, хаана гаргах вэ?

Гомдлыг бичгээр аль ч хэл дээр гаргаж болно. Гомдлыг и-мэйл, факс, шуудан болон НЗЭХ-ийн Вашингтон дахь офист хүргэж өгч болно. Гомдол бичих зааврыг Загвар захидлаас үзнэ үү.

Холбоо барих

Гомдол гаргах талаар асуух лавлах зүйл байвал дараах хаягаар танаас мэдээллээ өгнө:

Office of the CAO	T: + 1 202 458 1973
2121 Pennsylvania Avenue, NW	F: + 1 202 522 7400
Washington, DC 20433, USA	E-mail: cao-compliance@ifc.org

НЗЭХ-Д ГАРГАХ ГОМДЛЫН ЗАГВАР ЗАХИДАЛ

Хэнд: Нийшлийн зөвлөх, Эрхийг Хамгаалагчид
Олон улсын санхүүгийн корпорац
2121 Pennsylvania Avenue NW
Washington, DC 20433 USA
Fax: (+1) (202) 522-7400
e-mail: cao-compliance@ifc.org

Би\бид, _____, энэхүү гомдлыг _____
дараах байршилд _____

_____ төсөлд холбогдуулан гаргаж байна.

Гомдлыг дараах этгээдийг төлөөлөн гаргаж байна _____

_____ (хамаарахгүй бол орхих).

Би\бид _____

_____ нэртэй газар оршин суудаг (болвол газрын зураг хавсаргах). Надтай\
бидэнтэй дараах хаягаар холбоо барьж болно. Хаяг, утас ба факсны дугаар, имэйл
хаяг өгөх _____

Би\бид бидний тухай мэдээллийг нууцлахыг хүсч байна (хамаарахгүй бол орхих).

Би\бид төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд дараах байдлаар өртсөн эсвэл өртөж
болзошгүй байна: _____

Гудамжны хаяг

Шуудангийн хаяг (дээрхээс өөр бол)

Улсын код

Утас, Факс, Имэйл

Хэрэв боломжтой бол дараах мэдээллийг гаргаж өгөх:

Төслийн нэр, байршил, үйл ажиллагааны чиглэл (болвол газрын зураг хавсаргах)

Асуудлыг шийдвэрлүүлэх талаар миний\бидний авсан арга хэмжээ (огноо, хугацаа
зэрэг мэдээлэл багтаах) _____

Асуудлыг шийдвэрлүүлэх талаар хандсан хүмүүсийн нэрсийн жагсаалт (болвол харилцсан бичиг захидлын хувийг хавсаргах).

Гомдлыг дэмжих, нотлох бусад баримт мэдээлэл хавсаргах.

Үүний дээр дараах асуултаудад хариулна уу?

Энэхүү гомдлыг би/бид дараах байдлаар шийдвэрлэхийг хүсч байна: (НЗЭХ нь гомдлыг хүссэн байдлаар шийдвэрлүүлнэ гэж баталгаа өгөхгүй харин энэхүү мэдээлэл нь шийдэл хайхад дөхөм болгох зорилготой.)

Холбогдох бусад мэдээ материалын хувийг хавсаргах.

Жич: Хэрэв хүсвэл НЗЭХ нь гомдол гаргагчдын мэдээллийг нууцлах бөгөөд харин нэргүй гомдол хүлээж авахгүй.

Гомдлыг дэмжих, нотлох зорилгоор мэдээлэл материалыг мөн нууцлан гаргаж өгч болно. Тэдгээрийг гаргаж өгсөн талын зөвшөөрөлгүй нууцлалаас гаргахгүй.

Гомдолд холбогдох талууд, түүний дотор төслийн санхүүжүүлэгч, ОУСК, МИ-ГА-гийн ажилтнууд гомдлын талаарх мэдээлэл авна гэдгийг гомдол гаргагч мэдэж байх нь зүйтэй. Гомдол гаргагчид НЗЭХ-чид ямар мэдээллийг нууцлалаас гаргаж болохгүйг эхнээс нь тодорхой зааж өгөх хэрэгтэй. Гомдлыг хэрхэн хэлэлцэх талаар гомдол гаргагчтай тохирно.



Уул уурхайн нөлөөллөөр уламжлалт усны нөөцийг хомсдуулах, бүрмөсөн ширгээх, хангалтгүй хэмжээ ба чанарын зөврийн усаар үйлчилж байгаа тухай гомдол хөдөө орон нутгаас ирэх нь түгээмэл болсон. Дэлхийн банк, ОУСК, ЕСБХБ, АХБ зэрэг Монгол улсад тусламж үзүүлэгч банкууд бүгд уул уурхайн салбарт чиглэсэн санхүүжүүлэлт хийдэг. Гэтэл уул уурхайгаас учрах хохирлыг арилгахад гаргаж буй хөрөнгө оруулалт нь нийт хөрөнгө оруулалтын 1 хувьд хүрдэггүй. Хөдөө орон нутагт хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, уламжлалт ус ба бэлчээр ашиглах эрх, амьжиргаатай байх эрх, нүүдэлч ахуй соёлоо хамгаалах эрхийг зөрчсөөр байна.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ (АХБ) ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ



АХБ-ны одоогийн Хяналтын механизм нь 2012 оны 5 сарын 24-нд хүчин төгөлдөр болсон¹. Уг механизм хоёр үүргээс бүрдэнэ:

- Асуудал шийдвэрлэх үүргийг Тусгай төслийн чиглүүлэгч (ТТЧ - SPF) удирддаг
- Нийцлийг хянах үүргийг Нийцлийг хянах зөвлөл (НХЗ-СРР) гүйцэтгэдэг

Гомдлыг хэн, юун тухай гаргах вэ?

- Хоёр ба түүнээс дээш тооны нөлөөлөлд өртсөн хүмүүс
- АХБ-ны дэмжлэгтэй төслийн нөлөөллөөр шууд хохирол учирсан эсвэл хохирол учирч болзошгүй бол

Гомдолд Хариуцлагын механизмын дээрх хоёр үүргийн алийг сонгож байгааг тодорхой тусгах. Гомдол хүлээж авах ажилтан гомдол хүлээж авсныг мэдэгдэж, таны сонгосон үүргийг хэрэгжүүлэгчид гомдлыг шилжүүлнэ (Нийцлийг хянах–НХЗ-д эсвэл Асуудлыг шийдвэрлэх– ТТЧ-д)

Итгэмжлэгдсэн төлөөлөгч:

Орон нутгийн бус төлөөлөгч өртсөн иргэдийг төлөөлж болох боловч энэ нь зөвхөн тухайн нутгийн төлөөлөгч олдохгүй тохиолдолд зөвхөн Хяналтын механизм зөвшөөрснөөр төлөөлүүлж болдог.

Гомдлын шалгуурууд:

Дараах шалгууруудад нийцсэн гомдолд Асуудал шийдвэрлэх ба Нийцлийг хянах ажиллагаа явагдана:

- Өртсөн иргэдийн нэрс тодорхой ба төлөөлөх итгэмжлэлийн баримттай төлөөлөгч гомдлыг мэдүүлж болно.
- АХБ-ны санхүүжилттэй төслийн учруулсан хохиролд гомдол гаргасан байх. Нийцлийг хянах газраар шалгуулахын тулд хохирол нь АХБ-ны бодлогыг зөрчсний улмаас учирсан байх шаардлагатай.
- Төсөлд өртсөн иргэд эсвэл тэдгээрийн төлөөлөгч нь гомдол мэдүүлэхийн өмнө АХБ-ны Үйл ажиллагааны хэлтэстэй асуудлыг шийдвэрлэх оролдлого хийсэн байх. Энэ нь та Үйл ажиллагааны хэлтэстэй холбогдож, санаа зовниулж буй асуудлыг таниулан, авах арга хэмжээг санал болгосон байх ба харилцсан бичгүүдийн бүртгэл хөтлөнө гэсэн үг юм.
- Буцалтгүй тусламж эсвэл зээлийг хааснаас хойш хоёроос дээш жил өнгөрсөн тохиолдолд гомдол мэдүүлэх боломжгүй.
- Төслийн худалдан авах ажиллагаанд гаргасан шийдвэрт гомдол мэдүүлэхгүй.

Гомдол үйлдэх хэл:

АХБ нь англи хэлээр бичсэн гомдлыг давуу гэж үзэх ч, бусад албан ёсны эсвэл АХБ-ны гишүүн орны үндэсний хэл дээр үйлдсэн гомдлыг хүлээж авдаг.

Гомдол ямар мэдээлэл тусгах вэ?

- Өөртсөн иргэд, төлөөлүүж байгаа бол төлөөлөгчдийн нэрс, холбоо барих мэдээлэл,
- Гомдол гаргагчид нэрээ нууцлахыг хүсч байгаа эсэх,
- Асуудал шийдвэрлэх эсвэл Нийцлийг хянуулахын аль үүргийг хүсч байгааг тодорхой тусгах
- Төслийн нэр, байршил ба товч тодорхойлолт бүхий мэдээлэл,
- Гомдол гаргагчдын өртсөн эсвэл өртөж болзошгүй шууд ба материаллаг хохирлыг тайлбарлах,
- Боломжтой бол хохирлыг АХБ-ны зөрчсөн тодорхой бодлоготой нь холбож

¹ 2012 оны 5 сарын 23-нд хүчингүй болсон 2003 оны Хяналтын механизмын бодлогыг одоо байгаа Хяналтын механизмын бодлого орлож байна.

- өгөх (Асуудлыг шийдвэрлүүлэх тохиолдолд энэ шаардлаггүй),
- АХБ-ны Үйл ажиллагааны хэлтэстэй асуудлыг эв эээр шийдвэрлүүлэх оролдлого хийсэн байдлаа тайлбарлах (нийцлийг хянуулах ажиллагаанд уг мэдээллийг өгөх шаардлагагүй),
 - Хүлээж буй үр дүн эсвэл хохирлыг барагдуулах арга хэмжээний санал, мөн
 - Өөр бусад холбогдох мэдээлэл эсвэл нотлох баримт бичиг.

Асуудал шийдвэрлэх газраар эхэлж орсон гомдлыг Нийцлийг хянах газарт шилжүүлэх бол тэр процессийн тайлбар, хүрсэн үр дүнгийн тухай мэдээлэл мөн өгнө.

Асуудал шийдвэрлэх аргыг төсөлд өртсөн иргэд, төслийн санхүүжүүлэгч/хэрэгжүүлэгч, бусад оролцогч талуудыг бүгдийг оролцуулан, албан бус, зөвшилцлийн аргаар тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилготой боловсруулсан болно.

ТТЧ гомдлыг шалгуур хангасан гэж дүгнэвэл, гомдол гаргагч нартай уулзалт зохион байгуулах, ярилцлага авах, төслийн баримт бичгүүдийг шалгах, АХБ-ны ажилтнуудтай уулзах зэргээр хянах ба үнэлгээ өгөх үйл ажиллагаа явуулна. ТТЧ нь талуудын байр суурь ба зорилгын тухай мэдээлэл, маргааныг шийдвэрлэх арга зам, санал бүхий тайлан гаргана. Маргааныг шийдвэрлэх оролдлого хийхийн тулд оролцогч бүх талуудаас мэдээлэл цуглуулах, хэлэлцээ хийх, зуучлах зэрэг аргуудаас хамтран сонгоно.

Хэрвээ талууд Асуудал шийдвэрлэх үед тохирч чадвал ТТЧ нь тохиролцсон шийдлийн хэрэгжилтэнд хяналт тавина. Талууд тохиролцоонд хүрсний дараа эсвэл өөр шалтгааны улмаас Асуудал шийдвэрлэх процессийг зогсоосон бол хохирсон иргэд гомдлыг нийцлийн хяналт руу шилжүүлэх хүсэлт гаргаж болно.

Нийцлийг хянах ажиллагаа нь АХБ тухайн төсөл дээр өөрийн бодлого, журмуудыг зөрчсөн эсэхэд дүн шинжилгээ хийдэг. НХЗ нь төслийг боловсруулах, бэлтгэх эсвэл хэрэгжүүлэх шатанд АХБ өөрийн бодлогоо баримталсан эсэхийг тогтоох мөрдөн шалгах ажиллагаа явуулж, баримтлаггүй бол тэрээр гомдол гаргачдад шууд болон материаллаг хохирол учруулсан байдлыг тогтооно.

НХЗ гомдол хүлээж аваад Удирдлагад уламжилж, 21 хоногийн дотор хариу ирүүлэхийг хүснэ. Түүний дараа, НХЗ нь гомдолд гаргасан үндэслэл, банкны Удирдлагын хариу болон бусад баримт бичгийг үндэслэн гомдол шалгуур хангасан эсэхийг тогтооно. НХЗ нь гомдлыг шалгуур хангасан гэж үзвэл Удирдах зөвлөлдөө хандаж нийцлийг хянах эрх олгохыг хүснэ. НХЗ-ийн мөрдөн шалгах ажиллагаанд төслийн газар дээр үзлэг хийх, холбогдох талуудтай уулзах, баримт бичиг шалгах ажиллагаа багтаж болно. Мөрдөн шалгах ажиллагаанд шаардагдах хугацаа нь хүсэлтийн ээдрээтэй байдал, холбодсох бодлого, зөрчлийн цар хүрээ зэргээс хамаардаг.

НХЗ-ийн мөрдөн шалгах ажиллагаа дуусмагц шалгалтаар тогтоосон байдлын тухай тайлан гаргана. НХЗ нь АХБ-ны бодлого зөрчснийг тогтоосон тохиолдолд банкны Удирдлага төслийг бодлогод нийцүүлэх арга замыг санал болгоно. Удирдлагын санал болгосон үйл ажиллагаанд НХЗ саналаа өгөх ба зөрчлийг арилгуулахад АХБ-ны зүгээс авах арга хэмжээг Удирдах зөвлөл нь тодорхойлж эцсийн шийдвэрийг гаргана. Залруулах бүх ажиллагааны хэрэгжилтэнд НХЗ хяналт тавина.

Нууцлал

Хэрэв өөрийн гомдлыг нууцлахыг хүсвэл тэр тухай ТТЧ-д гаргах гомдолд тодорхой бичих, үндэслэлийг гаргаж өгөх хэрэгтэй. Нууцлахыг хүссэн бол таны зөвшөөрөлгүйгээр таны нэр, холбогдох мэдээллийг задруулахгүй болно. Хүссэн дагуу нууцлалыг хадгалах боломжит бүх арга хэмжээ авах болно. Гэхдээ, нууцлалыг хүсэлтийн дагуу хадгалах нь гомдлыг хэлэлцэх явцад саад болохоор байвал цаашид хэрхэх тухай ТТЧ-ын албан тушаалтан холбоо барьж тохирох болно.

A. Үүргийг сонгох – Асуудал шийдэх эсвэл нийцлийн хяналт хийлгэх (Аль нэгийг сонгох)

- Асуудал шийдвэрлэх аргыг** төсөлд өртсөн иргэд, төслийн спонсор, бусад оролцогч талуудыг бүгдийг оролцуулан, албан бус, зөвшилцлийн аргаар тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилготой боловсруулсан болно.
- Нийцлийг хянах** ажиллагаа нь АХБ тухайн төсөл дээр өөрийн бодлого, журмуудыг зөрчсөн эсэхэд дүн шинжилгээ хийдэг. НХЗ нь төслийг боловсруулах, бэлтгэх эсвэл хэрэгжүүлэх шатанд АХБ өөрийн бодлогоо баримталсан эсэхийг тогтоох мөрдөн шалгах ажиллагаа явуулж, баримтлаагүй бол тэрээр гомдол гаргачдад шууд болон материаллаг хохирол учруулсан байдлыг тогтооно.

B. Нууцлал

Та нар өөрийн мэдээллийг нууцлах хүсэлтэй юу? **Тийм** **Үгүй**

C. Гомдол гаргагчид (Нэр усгүй гомдол хүлээж авахгүй. Дор хаяж хоёр төсөлд өртсөн гомдол гаргагч байна.)

Нэр ба хүйс (ноён, хатагтай)	Гарын үсэг	Байгууллага, албан тушаал (байгаа тохиолдолд)		Шуудангийн хаяг	Утасны дугаар (суурин\ гар)	Цахим хаяг

Итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл туслах (байгаа тохиолдолд). (Итгэмжлэгдсэн төлөөлөгч, гомдол гаргахад туслах талуудын талаарх мэдээллийг нууцлахгүй бөгөөд зөвхөн тэдгээр нь өөрсдөө гомдол гаргагч бол нууцалж болно)

Гомдол гаргачийн төлөөлөгч	Нэр ба хүйс	Гарын үсэг	Байгууллага албан тушаал (байгаа тохиолдолд)	Шуудангийн хаяг	Утасны дугаар (суурин\ гар)	Цахим хаяг

D. Төсөл

Төслийн нэр	
Байршил	
Товч тодорхойлолт	

Е. Гомдол:

АХБ-ны санхүүжилттэй төслөөс гомдол гаргагчдад ямар шууд болон материаллаг хохирол учирсан эсвэл учирч болзошгүй байна?

- 1.
- 2.

Гомдол гаргагчид нь АХБ-ны Үйл ажиллагааны газар болон МУ-д буй суурин төлөөлөгчийн газарт асуудлуудыг шийдвэрлүүлхээр хандаж байсан уу?

Тийм. Тийм бол, хэзээ, ямар хэлбэрээр, хэн хэнд хандаж байсан тухай мэдээлэл оруулах. Мөн ямар хариу эсвэл АХБ-аас авсан арга хэмжээний талаар оруулна уу.

№.

Ү. Нэмэлт мэдээлэл (сонголтоор)

1. Гомдол гаргагчид гомдлыг хэрхэн шийдвэрлүүлэх, ямар үр дүн гаргах хүсэлтэй вэ?

2. Өөр нэмэх зүйл байвал энд бичнэ үү?

Энэ маягтыг бөглөсөн хүний нэр: _____

Гарын үсэг: _____

Огноо: _____

Гомдлыг шуудан, факс, цахим шуудангаар эсвэл биеэр дараах хаягаар АХБ-ны аль ч суурин төлөөлөгчийн газар хүргэж өгч болно:

Complaint Receiving Officer (CRO), Accountability Mechanism

ADB Headquarters, 6 ADB Avenue, Mandaluyong City 1550, Philippines,

Telephone number: +63-2-6324444 local 70309, Fax: +63-2-6362086,

E-mail: amcro@adb.org



Газар эзэмших, орон гэртэй, амьжиргаа залгуулах аж ахуйтай байх эрхээ алдсан олон мянган өрхийн тоо улам нэмэгдсээр байхад Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк зэргээс эдгээр эрхүүдийг сэргээн эдлүүлэх ажил хийхгүй байгаа тухай гомдол түгээмэл болсон.

НҮБ-ЫН БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ УДИРДАХ ЗАРЧМУУДААС:

- (a) Хүний үндсэн эрх, эрх чөлөөг *хамгаалах, хүндэтгэх ба хэрэгжүүлэх Төрийн Үүрэг*;
- (b) Хууль хэрэгжүүлэн ажиллах болон хүний эрхийг *хүндэтгэх Бизнесийн үүрэг*;
- (c) Эрх ба үүрэг зөрчигдсөн тохиолдолд *зөрчилтэй дүйцэх, зохистой, үр бүтээлтэй сэргээх* арга хэрэгслүүд хүртээмжтэй байлгах **Төр ба Бизнесийн үүрэг**.
- Бизнесийн хүний эрхийг хүндэтгэх үүрэгт бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхүүд буюу НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалаар баталгаажсан эрхүүд болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-ын “Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийн тухай” тунхаглалд зарчмуудад нийцүүлэн ажиллах шаардлагуудыг тусгасан болно.
 - Хүний эрхийг хүндэтгэх үүрэг бүх бизнес - үүнд үндэстэн дамнасан болон их бага хэмжээ, байршил, бүтэц, өмчлөл үл харгалзан бүх бизнест хамаарна.
 - Компанийн үйл ажиллагаанд ХАМААРАЛГҮЙ хэмээн гадна үлдэх нөлөө – бизнесийн өртөг зардлыг бодоход тооцохгүй орхидог өртөг буюу бизнест хамаагүй, сайн ба муу нөлөөллийг хүлээж авахыг сонгоогүй талд очих сөрөг нөлөөллийг тооцож тайлагнах шаардлага бий болсон. **ЖИШЭЭ:** усны хомсдол, иргэдийн аюулгүй байдал, байгалийн доройтол, агаарын бохирдол, дуу чимээ г.м.
 - **17.** Хүний эрхийг хүндэтгэх үүргээ хэрэгжүүлэхийн тулд бизнесууд компанийн бодлого, дотоод дүрэм журам боловсруулна. Үүнд: (a) Хүний эрхийг хүндэтгэн ажиллах бодлогын баримт бичиг; (b) Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийж эрсдлийн олж тогтоох, урьдчилан сэргийлэх, саруулах болон хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэсэн тухайгаа тайлгнадаг болох; (c) Өөрийн үйл ажиллагаагаар зөрчсөн эсвэл зөрчихөд оролцсон хүний эрхийг сэргээн эдлүүлэх, хохирлыг нөхөх журамтай болсон байх.
 - **18.** Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийхдээ өөрийн болон бусадтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас учрах шууд болон болзошгүй нөлөөллийг үнэлсэн байх. Ингэхдээ а\ өөрийн болон гаднаас мэргэжлийн мэдлэг туршлагыг татаж ажиллуулах; б\ нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн хүн амтай, холбогдох бусад талуудтай зөвлөлдөж үнэлгээ хийсэн байх. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд хийж болох боловч тэрхүү үнэлгээ нь бизнесийн үйл ажиллагааны нөлөөлөөд өртдөг нийтээр зөвшөөрсөн хүний бүх эрхүүдэд нөлөөлөх байдлыг үнэлэх шаардлагатай. Ингэхдээ нөлөөлөл нь эмэгтэй ба эрэгтэй хүмүүст өөр өөрөөр тусдаг болон бусад эмзэг бүлгүүдийг тусгайлан үнэлэх шаардлагатай.
 - **19.** Хүний эрхийн сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх эсвэл арилгах зорилгоор хийсэн үнэлгээний мэдээллийг холбогдох дотоод тогтолцоонд суулгаж өгөх шаардлагатай. (a) Зохистой суулгаж өгсөн байхын тулд: (i) сөрөг нөлөөллөөс сэргийлэх, арилгах асуудлыг компанийн зохих эрх мэдэл бүхий түвшинд хариуцуулсан шаардлагатай; (ii) Дотоод шийдвэр гаргалт, төсөв батлах болон хяналтын тогтолцоо нь нөлөөллийг зохистой шийдвэрлэх нэгжүүд юм.

- **22.** Хохирлыг нөхөх – бизнесээс хүний эрхийг зөрчсөн бол албан ёсоор хохирлыг нөхөх эсвэл нөхөхөд оролцох үүрэгтэй.
- **29.** Гомдлыг барагдуулах үүргээ хэрэгжүүлэхийн тулд компанийн үйл ажиллагаа эрхлэх түвшинд гомдол хүлээн авч барагдуулах нэгж байгуулан хувь хүмүүс болон нутгийн бүлгүүдийн гомдлыг барагдуулна.

Бусад эрх сурвалжаас:

• Орон нутагт:

- o Нутгийн иргэн, бүлэг иргэдийг хүчээр\албадан нүүлгэн шилжүүлэхээс таггалзах
- o Нутгийнхны эдийн засаг, амьжиргааны аж ахуйг хамгаалах
- o Хамтын зөвшилцлийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах. Үйл ажиллагаа явуулж буй орны төр засгийн бүх шатанд харилцаатай байдаг тул бизнесүүд өөрийн үйл ажиллагаа, ажиллагсад, үйлчлүүлэгч ба нутгийнханд холбогдох асуудлууд дээр санал хэлэх эрх ба үүрэгтэй.
- Өөрийн үйл ажиллагааг хамгаалах хамгаалалтын алба ажиллуулж буй компани хүч хэрэглэх үйл ажиллагаанд тогтоосон олон улсын стандарт, удирдамжийн хүрээнд ажиллах баталгаагаа гаргах үүрэгтэй.

Хүний эрхийг хүндэтгэх буюу “хүний эрхийг зөрчихгүй” байх үүрэг:

- ...хүч хэрэглэх салбарт тогтоосон олон улсын стандарт ба удирдамжийг дээдлэх (НҮБ-ын Хууль хэрэгжүүлэгчийн хүч ба галт зэвсэг хэрэглэх Үндсэн зарчмууд, НҮБ-ын Хууль хэрэгжүүлэгчийн ёс зүйн дүрэм);
- ...хэрэв хамгаалалтын алба байгуулахад санхүүгийн эсвэл материаллаг тусламж үзүүлэх бол тэдгээр нь хүний эрхийг зөрчихгүй байх шаардлага болон олон улсын хүний эрхийн хуулийг зөрчилтэй эвлэрэхгүй тухай тов тодорхой зааж оруулах;
- ...хувиасаа болон нийтийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг шүүмжлэх;
- ...хөрөнгө оруулалтын өмнөх ба дараах шатанд компанийн дотоод болон гаднах бүх сонирхогч талуудтай байнга зөвлөлдөж байх;
- ...компанийн үйл ажиллагааны цар хүрээнд, компанийн дотоод үйл ажиллагаанд хүний эрхийн талаар таниулах ажил зохиох;
- ...компанийн үйл ажиллагаа- хөрөнгө оруулалт хийхийн өмнөх, төсөл судлах, төлөвлөх шатанд- хүний эрхийн зөрчилд холбогдож болзошгүй эрсдэл, хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах хэсгүүдийг олж тогтоох;
- ...нутгийнхны эсвэл бүсийн хүн амын хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг хөрөнгө оруулалтын функц тус бүрийн хүний эрхэд (санаатай ба санамсаргүй) нөлөөлөх байдлыг шинжлэн үнэлэх;
- ...хөрөнгө оруулалт хийгдсэний дараах шатанд дотоод “үйл ажиллагааны эрсдэл”-ийг олж тогтоох. Үүнд худалдан авалт, логистик, засаг захиргаатай харилцах, хүний нөөцийн менежмент, эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, борлуулалт ба маркетинг зэрэг байж болно.

Байгаль орчин:

- Эрүүл мэнд ба байгаль орчныг хамгаалах зорилго бүхий журам ба аргачлалыг өөрийн үйл ажиллагаа ба бүтээгдэхүүнд хэрэгжүүлэх.
- Компанийн бүх шат дамжлага, үйл ажиллагаанд жигд ба тогтмол хэрэгжүүлэх

удирдамж боловсруулж хэрэгжүүлэх.

- Болгоомжтой ажиллагааны буюу эмзэг хэсгүүдийн эрсдлийн менежментийн үйл ажиллагааг хянах зөвлөлийг удирдлагын хэмжээнд байгуулж ажиллуулах.
- Хоёр урсгалтай, идэвхитэй, ил тод, үйл ажиллагаа эхлэх шатнаас бүх талуудтай харилцах харилцааны хэлбэр бий болгох. Энэхүү харилцаа нь тодорхой бус, эмзэг асуудлууд, эрсдлүүд болон эдгээрт холбогдох лавлагаа, гомдолтой ажиллах зорилготой байх. Олон талт уулзалт, семинар хэлэлцүүлэг, фокус бүлэг, олон нийтийн санал цуглуулалт, вебсайт ба хэвлэмэл мэдээллийг үүнд ашиглах.
- Холбогдох чиглэлээр шинжлэх ухааны судалгаа, түүний дотор бие даасан болон нийтийн судалгааг дэмжих, үндэсний ба олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.
- Эмзэг, сөрөг нөлөөллийн эрсдэл бүхий эсвэл нөлөөлөл нь тодорхойлогдоогүй үйлдэрлэлийн технологи, бүтээгдэхүүний чиглэлээр ажилладаг, мэдээлэл солилцооны зэрэг салбарын хамтын ажиллагаанд нэгдэх.

Байгаль орчинд хариуцлагатай компанийн үйл ажиллагаа:

- Компанийн алсын бодлого, стратеги, төлөвлөлт зэрэг үндсэн баримт бичгүүдийг тогтвортой хөгжлийн гурван суурь – эдийн засгийн баялаг, байгаль орчны чанар ба нийгмийн тэгш байдлыг хангах зорилгод нийцүүлэн шинэчлэх.
- Тогтвортой байдлын зорилт ба хэмжүүр үзүүлэлтүүд боловсруулж хэрэгжүүлэх (эдийн засаг, байгаль ба нийгмийн).
- Урт хугацаанд нийцлээс цааш алхах боломжид хүрэх үр дүн нь тодорхой заагдсан тогтвортой үйлвэрлэл ба хэрэглээний хөтөлбөр боловсруулах.
- Нийлүүлэгч, борлуулагч зэрэг бүтээгдэхүүний гинжин сүжээндээ ажиллаж байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааны хариуцлагыг түгээх.
- Зохистой үйл ажиллагаа болон зөв үйлдлийн түвшин тогтоох зорилгоор дотоод ажиллагаа, салбар болон олон улсын сайн дурын дүрэм зарчим, санаачлагуудад нэгдэх.
- Глобал үйлвэрлэлийн стандарт, өөрийн тогтоосон тогтвортой байдлын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа байдлыг хэмжих, хянах ба тайлагнах.
- Бүх сонирхогч талуудтай ил тод, нээлттэй, талцаагүй байдлаар хэлэлцүүлэг явуулах боломжийг баталгаажүүлэх.

Технологи сайжруулах стратеги хандлагууд:

- Байгаль орчинд ээлтэй технологи хэрэгжүүлэх тухай компанийн бодлого тогтоох.
- Сонирхогч талуудад байгаль орчны талаарх тайлан, байгальд ээлтэй технологи хэрэгжүүлэхийн үр ашгийг харуулсан мэдээллийг түгээх.
- “Тогтвортой хөгжлийн дизайн” чиглэлд компанийн хөгжлийн бодлого судалгааг чиглүүлэх.
- Шинэ технологи ба бүтээгдэхүүн хөгжүүлэхдээ “амьдралын циклийн үнэлгээ” (LCA)-г хэрэглэдэг байх.
- Байгаль орчны технологийн үнэлгээ (EnTA) хэрэгжүүлдэг болох.
- Хөрөнгө оруулалт, гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч шалгаруулах тендерийн шалгуурт байгаль орчны наад захын стандартын шаардлага багтааж шалгаруулж байх.
- Салбарын хүрээнд түншлэн “хамгийн сайн технологи” (BAT)-г бусад байгууллагуудад хүртээмжтэй байлгах.



Улаанбаатарт гамшигийн түвшинд хүрсэн агаарын бохирдлоос болж хүн амын өвчлөл, хүүхэд ба жирэмсэн эхчүүдийн эндэгдэл өссөөр байхад орон сууц нэмж барих, үүний тулд нүүрсээр галлах ДЦС-дын хүчин чадлыг нэмэх, нүүрсийг “боловсруулсан” нэрээр үргэлжлүүлэн ашиглах бодлого хэрэгжүүлсээр байгаа нь хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байгаа тухай гомдол гарсаар байна.

АХБ, ЕХОБ болон Уур амьсгалын ногоон сангаас Улаанбаатар хотод “орлогод нийцсэн орон сууц, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөхгүй орон сууц” санхүүжүүлж байгаа бөгөөд тэдгээрийг дулаан ба цахилгаанаар хангахын тулд УБ хотын 2,3,4-р ДЦС-ын хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх, Багануурт 700 МВт ДЦС шинээр барих, уурын зуухуудыг сайжруулах ба нэмэгдүүлэх хөтөлбөрүүд, тэдгээрийг санхүүжүүлэх зээлийн гэрээнүүд батлагдаад байна. Эдгээр төслүүдээс хүний газартай, орон гэртэй, амьжиргаатай байх эрхүүдийг зөрчиж зохистой амьжиргааг хангах нөхөн олговор олгохгүйгээр “бүтээн байгуулалт” нэртэй газар чөлөөлөлт явуулж байна.

Сайтын линкууд file:///C:/Users/DELL/Downloads/KMBT_215_02325-3-3.pdf, <https://www.adb.org/countries/mongolia/country-documents>

МЭДЭЭЛЭЛ АВАХ ВЕБСАЙТЫН ХАЯГ:

Хүний эрхийн үндэсний комисс – www.nhrcm.gov.mn

Монгол улсын хуулийн нэгдсэн портал сайт – www.legalinfo.mn

Эмнэсти Интернэшнл Монгол - <https://www.amnesty.mn/>

Засгийн газрын мэдээлэл – www.open-government.mn

Байгаль орчны мэдээллийн сан– www.eic.mn

Гадаад харилцаа, худалдааны яам – www.mfat.gov.mn

Эрдэс баялаг, эрчим хүчний яам- www.mmre.energy.mn

Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сайт – www.iltodgeree.mn

Хүнс, хөдөө аж ахуйн яам – www.mofa.gov.mn

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл – www.un.org/ru/rights

НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн сайт -

<https://www.ohchr.org/en/issues/business/pages/businessindex.aspx>

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO) -

<https://www.ilo.org/beijing/countries-covered/mongolia/lang--en/index.htm>

Дэлхийн Банкны Хяналтын зөвлөл - <https://inspectionpanel.org/>

Олон улсын санхүүгийн корпорацийн НЗЭХ - <http://www.caombudsman.org/cases/>

Сэргээн босголтын банк - <https://www.ebrd.com/work-with-us/project-finance/project-complaint-mechanism.html>

Азийн хөгжлийн банкны Хариуцлагын механизм -

<https://www.adb.org/site/accountability-mechanism>

Оюу Толгойн Хяналт ТББ

Хаяг: СБД, Бага Тойруу, 44-204

Утас: 70122202

И-мэйл хаяг: otwatch@gmail.com.